



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 334

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин зохион
байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 44 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 2019 оны 268 дугаар тогтоолын 4.4, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хорих ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй, элэгдлээрээ өртгөө нөхсөн, нийт 92,430,874.47 (ерэн хоёр сая дөрвөн зуун гучин мянга найман зуун далан дөрвөн төгрөг дөчин долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий автомашины нээлттэй дуудлагын худалдааг (3 дахь) дахин зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Д.Дамдинцэрэн болон тогтоолд заасан байгууллагын даргад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан мэдээ, тайлангийн баталсан маягтын хамт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

0000615

C:\2019.07.22 16r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалт
2019 оны 07 дугаар сарын 22-ны
33.4 дугаар тогтоолын хавср

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗАР
ХОРИХ АНГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР
ДАХИН ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашины нэр, улсын бүртгэл, арлын, хөдөлгүүрийн дугаар	Ашиглалтад орсон он	Нийт гүйлт (мян.км)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	ТӨБЗГ-ын 2018 оны 531, 2019 оны 51 дүгээр тогтоолоор тогтоосон доод үнэ (төгрөг)	Хуульчилсан үнэ
1.403 дугаар нээлттэй хорих анги								
1	Фургон, 16-24 УНЦ (арал 0420657)	2010	420	18,100,000.00	18,100,000.00	-	800,000.00	
	Дүн			18,100,000.00	18,100,000.00	-	800,000.00	
2.435 дугаар хаалттай хорих анги								
2	Фургон, 84-35 ДАР (арал 0420622)	2010	343	18,100,000.00	18,100,000.00	-	800,000.00	
3	Фургон, 57-48 ДАХ (арал 0418540)	2016	347	31,659,574.47	31,659,574.47	-	800,000.00	
	Дүн			49,759,574.47	49,759,574.47	-	1,600,000.00	
3.Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллага								
4	Истана, 76-50 УБЛ (kpdab6e81tp007614)	2011	385	6,471,300.00	6,471,300.00	-	700,000.00	
	Дүн			6,471,300.00	6,471,300.00	-	700,000.00	
4.Хөвсгөл аймаг дахь ШШГГ								
5	Фургон, 39-82 ХӨВ, (арал 374100a0420820)			18,100,000.00	18,100,000.00	-	2,000,000.00	1,
	Дүн			18,100,000.00	18,100,000.00	-	2,000,000.00	1,
Нийт дүн				92,430,874.47	92,430,874.47		5,100,000.00	2,
				(ерэн хоёр сая дөрвөн зуун гучин мянга найман зуун далан дөрвөн төгрөг дөчин долоон мөнгө)				(та